



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№92 /536/

2023.06.08

Цаг үе, үйл явдал

ЗХЖШ-ЫН ДАРГА БРИГАДЫН ГЕНЕРАЛ С.ГАНБЯМБА ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИУДАД АЖИЛЛАЛАА



ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба Зэвсэгт хүчний 337, 350 дугаар ангид ажиллалаа.

Түүнийг дагалдан ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, Бодлого, стратегийн удирдлагын газрын дарга хурандаа С.Ванчинхүү, Материал, техникийн газрын дарга хурандаа Б.Түвшинтөр, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат, Тусгай хүчний цэргийн штабын дарга хошууч генерал Л.Гансэлэм нарын албан тушаалтнууд ажиллав.

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн хувьд үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ БХЯ, ЗХЖШ-ын дэмжлэг, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан ангийн байрлал дахь объектуудын засвар, тохижилт болон зарим бүтээлч ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, иж бүрэн камержуулалтын системийг шинээр суурилуулсны зэрэгцээ "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 1500-аад модыг тарьж ургуулж байгаа аж.

Энэ үеэр бригадын генерал С.Ганбямба тус ангид хийгдэж буй бүтээн байгуулалт, зарим

явцтай танилцаж, тэдэнд амжилт хүслээ.

Дараа нь тус ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, бодлого зорилт, офицер, ахлагч нарын нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлуудын талаар мэдээлэл өгөв. Тэрээр бие бүрэлдэхүүнд хандан "Өнөөдөр тус ангийн үйл ажиллагаатай танилцлаа. Ангийн цаашдын хөгжилд томоохон түлхэц болохуйц маш чухал бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байгаа харлаа. Хүн нэг бүрийн сэтгэл зүтгэл ч мэдрэгдлээ. Ер нь офицер, ахлагч нарын өнгөтэй өөдтэй байхаас энэ ангийн цаашдын хэтийн төлөв ихээхэн шалтгаална. Цалингийн сүлжээ, зэрэглэлд өөрчлөлт орсныг та бүхэн мэдэж байгаа. Ингэснээр офицер, ахлагч нарын цалин бодитоор, мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа. Мөн Зэвсэгт хүчнийг улам бэхжүүлэх, хөгжүүлэх хүрээнд зэвсэг, техникийн шинэчлэлийн ажлууд хийгдэж байгаа. Бид өөрсдөө зохион бүтээж эхэлсэн. Бусад улс оронтой тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд тодорхой ажлууд ч хийгдэнэ. Улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалах зүйл олон ч бид асуудлуудаа эрэмбэлээд шат дараатайгаар шийдэхийг зорин ажиллаж байна. Бид "Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бэхжүүлнэ" гэж хуулиндаа тусгасан. Үүний тулд хүн бүр мэдлэг чадвар, үүрэг гүйцэтгэх боломжоо нэмэгдүүлэх нь чухал. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын офицер, ахлагч нарын ёс зүй, бие бялдрын түвшинг тогтоох үзлэг"-ийг бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулж байгаа. Нэгдсэн зохион байгуулалтаар дадлага сургуулилт хийхээс илүүтэй хувь чөлөөт цагаа ашиглаад өөрийгөө хөгжүүлж, дайчлах хэрэгтэй. Ангийн удирдлагууд энэ боломжийг нь олгоно гэдэгт итгэлтэй байна. Салбарын удирдлагын зүгээс Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх чиглэлд онцгой анхаарч, дэмжиж байгаа. Өнөөдөр манай салбарын офицер, ахлагч нарын хувьд гадаадын олон улс оронд боловсрол эзэмшиж байна. Бидэнд сурч хөгжих боломж их бий. Харьцангуй залуугаараа тэтгэвэрт гардаг. Дараа нь өөр талбарт ч ажиллаж болно. Зэвсэгт хүчин маш олон давуу талыг олгож байна. Үүний зэрэгцээ тангараг өргөсөн бид дор бүрнээ хариуцлагатай байх шаардлагатай. Зэвсэгт хүчний ирэх зууны хөгжил бид бүхнээс ихээхэн шалтгаална. Хандлага, ёс зүйгээрээ манлайлья. Бид нийгмийн манлайлаа, толь нь байх учиртай" гэдгийн онцлоод нийт бие бүрэлдэхүүнд ажлын амжилт, аз жаргал, эрүүл энхийг хүсэв.

Үүний дараа ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба Зэвсэгт хүчний 350 дугаар ангид ажилласан юм. Энэ үеэр тус ангийн захирагч дэд хурандаа Б.Ууганбаяр ангийн үүрэг гүйцэтгэлт, бэлэн байдал, хийж хэрэгжүүлсэн болон цаашид төлөвлөсөн ажлуудын талаар мэдээлэл өгсөн юм.

Үргэлжлүүлэн албаны бүрэлдэхүүн Дайчин алдрын танхим, спорт заал, Эрүүл мэндийн төв болон бусад объектуудаар орж, тус ангийн үйл ажиллагаатай танилцав.

Төгсгөлд нь тус ангийн нийт бие бүрэлдэхүүнтэй уулзаж, тэдний санал хүсэлтийг сонслоо.



ЗХЖШ-ын даргыг Зэвсэгт хүчний 337 дугаар ангид хүрэлцэн ирэхэд Хүндэт харуул жагсаж утгсаны дараа тус ангийн захирагч хурандаа Э.Батсайхан ангийн үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлт, дэвшүүлсэн зорилго зорилт, хэрэгжүүлж буй ажлууд болон тулгамдсан асуудлуудын талаар танилцуулсан юм.

барилга байгууламжтай танилцахын зэрэгцээ тулгамдсан асуудлуудыг нь шийдвэрлэх хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай ярилцаж тодорхой чиглэл гаргалаа. Мөн Нисгэгчгүй нисэх хэрэгслийн төвөөр зочилж, гар сэтгэл нийлсэн залуусын өөрсдөө бүтээж байгаа дроны туршилт, судалгаа, ажлын



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	10


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,440	3,447
EUR	3,714	3,729
CNY	487	488
RUB	41.40	42
JPY	24.85	25
KRW	2.59	2.62

ЗУРХАЙ



2023.06.08 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 20

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН
МОГОЙ САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ УЛААН
БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:

Сайн нөхөртэй нөхөрлөнө

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

04.54-20.48

Барилдлага:

Идэр

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Тийн мэдэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 689,945,045

Эдгэрсэн

Нийт: 6,890,525

Нас барсан

Нийт: 662,389,456

Цахим шууданд

ХОЁРДУГААР ШАТНЫ ҮЗЛЭГИЙГ ЯВУУЛЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгийн хоёрдугаар шат Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Хужир булан дахь Сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн амжилттай явагдаж байна.

Тухайлбал энэ сарын 7-ны өдөр ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон Зэвсэгт хүчний 310, 013 ангийн нийт бие бүрэлдэхүүн бие бялдрын

бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэгтээ хамрагдлаа.

Үзлэгийг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон дэд ажлын хэсэг 6 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн түүвэрчилсэн байдлаар зохион байгуулж байгаа бөгөөд уг дэд ажлын хэсэг нь батлагдсан ерөнхий удирдамжийн дагуу, тогтоосон хугацаанд үзлэгийг шударга, нээлттэйгээр явуулж, цаашид офицер, ахлагчийн албыг хөгжүүлэх, чадваржуулахад чиглэгдсэн бодлогыг тодорхойлон холбогдох албаны удирдлагуудад тайлагнаж юм.

ГАМШГИЙН АЮУЛЫН ТУХАЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР АЖИЛЛАХ ДАДЛАГА СУРГУУЛИЙГ ОРОН ДАЯАР ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



даван туулах чадавхыг дээшлүүлэх зорилготой тус сургуульд БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, харьяа байгууллагуудын бие бүрэлдэхүүн оролцов. Энэ үеэр зарлан мэдээллийн дохиог хүлээн авах, бие бүрэлдэхүүнд шуурхай хүргэх, аюулгүй байдлыг хангах, албаны өрөө, танхимд "Нуугд, суу, хүлээ" зарчмыг баримтлан өөрийгөө хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, гамшгийн үед дэмжлэг үзүүлэх томилгоот хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, аюулгүйн гарцаар гарч тогтоосон байранд цугларах, бие бүрэлдэхүүнийг бүртгэх, дараагийн ажиллагаанд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэв.

Мөн нийт бие бүрэлдэхүүнд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга хурандаа Д.Дугаррагчаа дадлага, сургуультай холбоотойгоор зааварчилгаа өглөө.



"Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож "онц байдал" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвт стратегийн команд штабын сургууль амжилттай явагдаж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран анх удаагаа зохион байгуулж байгаа тус сургуулийн хүрээнд өнөөдөр 16:00 цагт орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгууллаа.

Төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг жигдрүүлэх, улсын гамшигтай тэмцэх болон төрийн цэргийн байгууллагын чиглэлийн төлөвлөгөөг тодотгох, нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, гамшгийг хохирол багатай

МАНАЙ ЭНХИЙГ САХИУЛАГЧИД НҮБ-ЫН МЕДАЛИАР ШАГНАГДАВ



БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай UN-MISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн багийнхны талаарх мэдээллийг НҮБ-ын веб сайтад онцлон түгээсээр байна. Тухайлбал, онцгой гавьяа байгуулсан Монгол энхийг сахиулагчдыг НҮБ-ын медалиар шагнасан бөгөөд үүний цөөнгүй хэсэг нь эмэгтэй цэргийн алба хаагчид байлаа хэмээн онцолжээ.



Ахмад Д.БОЛОР

Мөн Суданд борооны улирал эхэлсэнтэй холбогдуулан Монгол, Пакистан энхийг сахиулагчид хамтран Бентью хотод завьтай эргүүл хийж, усны түвшинг шалгахын зэрэгцээ үерт автсан нутгийн иргэдэд тусламж дэмжлэг үзүүлж байна гэжээ.

Монгол цэргүүдийн үүрэг гүйцэтгэлтэд Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг сэтгэл хангалуун байдлаар илэрхийлж, "Монгол Улс даян дэлхийд эвийг эрхэмлэгч улс орон гэдгийн баталгаа бол Монгол Улсын энхийг сахиулагчид. Дэлхий дахинд болон бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг тогтоох, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах зорилтыг хэрэгжүүлэхэд төр засагт дэмжлэг үзүүлэгч дайчдадаа баярлалаа" хэмээн цахим хуудаснаа талархал илэрхийлжээ.

ОЮУТАН ЗАЛУУС ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ҮЙЛСЭЭР БАХАРХАВ



Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр анги Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг оролцуулж эхэлсний 20 жилийн ойн хүрээнд энхийг сахиулагчдын түүхэн замнал, алдар гавьяаг мөнхжүүлэх, иргэн цэргийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг Налайх дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтэд чиглэн зохион байгуулж байна.

Үүний нэг нь 6 дугаар сарын 8-ны өдөр дүүргийн Политехникийн коллежийн оюутан, сурагчдад энхийг сахиулагч дайчдын түүхээр "аялуулсан" өдөрлөг байв. Арга хэмжээг ангийн захирагчийн сургалт, бэлтгэл хариуцсан орлогч дэд

хурандаа Л.Чинзориг нээж өдөрлөгийн зорилгыг дурдсан бол Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга ахмад Г.Амгалан "Инженерийн цэргийнхэн" сэдэвт танилцуулгыг хүргэж, энхийг дэмжих ажиллагааны оролцоо, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэж, "Иракт өнгөрүүлсэн 190-хоног" баримтат найраглалыг сонирхууллаа.

Оюутан сурагчид "Энхийг сахиулах үйлс гэдгийг цэнхэр малгайтай цэргийн алба хаагчдын зургаар л төсөөлж ирсэн. Харин улс орондоо ямар өндөр ач холбогдолтой, үр нөлөөтэй гэдгийг та бүхнийг мэдээллээр ойлгож авлаа. Монгол Улсын энэ цагийн бахархал бол энхийг сахиулагчид юм байна" хэмээн сэтгэгдлээ хуваалцаж байсан юм.

Хошууч Э.ХАШЦАХИУР

БИЕИЙН ТАМИРЫН БЭЛТГЭЛЖИЛТИЙН ҮЗЛЭГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох хоёрдугаар шатны үзлэг ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, нэгтгэл, ангиудад эхэллээ.

Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Хужир булан дахь Сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн 6 дугаар сарын 6-ны өдөр командлал болон Зэвсэгт хүчний 119, 326 дугаар ангийн офицер, ахлагч нарын биеийн тамирын бэлтгэлжилтийн үзлэгийг явуулсан бол 6 дугаар сарын 7-ны энэ өдөр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн алба хаагчдыг хамруулж байна.

Ажлын хэсгийнхэн биеийн тамирын бэлтгэлжилтийн дараа

онолын мэдлэг, ёс зүй, сэтгэл зүйн сорил, жагсаалч байдал гэх чиглэлээр нэгтгэл, анги бүрт нь энэ долоо хоногтоо багтаан явуулах бөгөөд Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиудын дараа орон нутаг дахь ангиудад ажиллана.

Энэхүү үзлэг нь Зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор гурван үе шаттайгаар зохион байгуулагдаж байна.

Дэд хурандаа С.ЭНХТАЙВАН